



### ЦУ №06(44)

#### Цаг уур, агаарын бохирдол

Ус, цаг уурын хүрээлэнгийн мэдээгээр 2010 оны 6 дугаар сард хамгийн их хур тунадас Баянхонгор аймгийн Галуут суманд (94.9 мм) орсон байна. Агаарын хамгийн их температур Дорнод аймгийн Чойбалсан суманд 41.2 хэм дулаан, хамгийн бага температур Улаанбаатар хотын Тэрэлж, Хөвсгөл аймгийн Хатгал суманд -3.3 хэм хүйтэн байлаа. Салхины хамгийн их хурд Увс аймгийн Завхан суманд 28 м/сек хүрсэн байна.

Агаарын дундаж температур 2010 оны 6 дугаар сард олон жилийн дунджаас 2.9 хэм дулаан байсан бол өмнөх оны мөн үед 0.2 хэм дулаан байсан байна.


Азотын давхар ислийн хоногийн дундаж агууламж 2010 оны 6 дугаар сард Улаанбаатар хотын 32-ын тойрог, 13-р хороолол, Офицеруудын ордон орчимд тус бүр 1 удаа, 10 микроноос бага хэмжээтэй тоосны агууламж 1-р хороолол орчимд 1 удаа агаарын чанарын стандарт дахь хүлцэх хэм хэмжээнээс давсан байна (Зураг 1. 2).

#### Аюулт үзэгдэл, осол


Аюулт үзэгдэл, осол 2010 оны эхний хагас жилийн байдлаар 1587 удаа гарсны улмаас 145 хүн амь насаа алдаж, гамшгийн хэмжээнд хүрсэн болон зудын байдалтай аймаг, сумын хэмжээнд 8.8 сая мал хорогджээ. Аюулт үзэгдэл, ослыг төрлөөр нь авч үзвэл объектын түймэр 1337 удаа, хүчтэй цасан болон шороон шуурга 22 удаа, 3-аас дээш магнитудын хүчтэй газар хөдлөлт 23 удаа бүртгэгджээ. Аюулт үзэгдэл, ослын улмаас 476.4 тэрбум төгрөгийн хохирол учирсан байна.

Өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад аюулт үзэгдэл, ослын тохиолдлын тоо 232 тохиолдол буюу 17.1 хувь, амь насаа алдсан хүний тоо 62-оор буюу 74.7 хувь, хорогдсон малын тоо 8.5 сая толгойгоор тус тус өсчээ. (Хүснэгт 1).

Зураг 1.



Зураг 2.



Хүснэгт 1.

#### Аюулт үзэгдэл, осол, жил бүрийн эхний хагас жилийн байдлаар\*

Үзүүлэлт	2008 I-VI	2009 I-VI	2010 I-VI	2010 I-VI / 2009 I-VI %
Аюулт үзэгдэл, ослын тохиолдлын тоо	1 683	1 355	1 587	117.1
Аюулт үзэгдэл, ослын улмаас амь насаа алдсан хүний тоо	164	83	145	174.7
Шатсан гэр, орон сууцны тоо	623	380	854	224.7
Аюулт үзэгдлийн улмаас хорогдсон, устгасан мал, амьтан, мян.тол	785.7	313.2	8 822.3	28.2 **
Объектын түймрийн тоо	1 424	1 177	1 337	113.6
Учирсан хохирлын хэмжээ, тэрбум төг	28.2	2.8	476.4	169.9 **

Тайлбар: \*-Онцгой байдлын ерөнхий газрын мэдээ

\*\* -Дахин их